

АГУУЛГА

Нэр	Хуудас
Оршил	2
Нэг. ТОВЧ ТАЙЛБАР, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ	3
Хоёр. МАЛ БҮХИЙ ӨРХ, МАЛЧДЫН ТОО, ТЭДГЭЭРИЙН СОЁЛ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТ	6
Гурав. МАЛ ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, СҮРГИЙН БҮТЭЦ	9
Дөрөв. ТЭЖЭЭВЭР АМЬТАД	17
Дөрөв. ДҮГНЭЛТ	20

ОРШИЛ

Манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр суурь эзэлдэг билээ. Иймээс монгол улсын үндсэн хуульд мал сүргийг үндэсний баялаг мөн гэж томъёолж, мал тооллогын ажлыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Үндэсний Статистикийн газрын удирдамж зааврын дагуу аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсүүд жил бүрийн 12 дугаар сарын 7-17-ны өдрүүдэд “Мал, тэжээвэр амьтдын тооллого”-ыг зохион байгуулж явуулдаг билээ.

Үүний дагуу дүүрэгт 2013 оны мал тооллогыг нийслэлийн Засаг даргын А/997 тоот захирамжийг үндэслэн дүүргийн Засаг даргын 2013 оны 12 дүгээр сарын 05-ны өдрийн А/559 тоот захирамжаар энэ оны мал, тэжээвэр амьтдын тооллого явуулах ажлын хэсэг байгуулж, ажиллах удирдамжийг батлуулан тооллогын хугацаанд амжилттай зохион байгуулж явууллаа.

Мал тооллогын дүнг нэгтгэн дүгнэсэн энэхүү судалгаа нь дүүргийн мал аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулахад суурь мэдээлэл болно гэдэгт итгэлтэй байна.

I. ТОВЧ ТАЙЛБАР, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Малчин өрх: Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа өрхийг хэлнэ.

Малтай өрх: Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг хэлнэ.

Малчид: Жилийн 4 улирлын туршид мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Таван хошуу малыг бодод шилжүүлэх коэффициент:

- 1 тэмээ – 1.5 бод
- 1 адуу – 1 бод
- 1 үхэр – 1 бод
- 6 хонь – 1 бод
- 8 ямаа – 1 бод

Таван хошуу малыг хонин толгойд шилжүүлэх коэффициент:

- 1 тэмээ – 5 хонь
- 1 адуу – 7 хонь
- 1 үхэр – 6 хонь
- 1 хонь – 1 хонь
- 1 ямаа – 0.9 хонь

Нас гүйцсэн мал: Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хэлнэ.

- Тэмээ – 4 настай, 5 ба түүнээс дээш настай
- Адуу – 3 настай, 4 ба түүнээс дээш настай
- Үхэр – 2 настай, 3 ба түүнээс дээш настай
- Бог мал /хонь, ямаа/ - тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал:

- **Тэмээ** – Өнгөрсөн жилийн төл, 2, 3 настай
- **Адуу** – Өнгөрсөн жилийн төл, 2 настай
- **Үхэр** – Өнгөрсөн жилийн төл

Төл мал: Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч: Малын төрөл бүр дээр сүүлийн 2 насны эм малыг хэлнэ.

Малын тоо, толгойнөсөлт: Оны эцсийн малаас оны эхний малыг хасч гаргана. Харьцангуй үзүүллэтүүдийг гаргахдаа оны эцсийн малын тоог эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ. Малын өсөлтийн орлого тал нь төл бойжилт болон худалдаж авсан, шилжиж ирсэн мал, зарлага тал нь худалдсан, шилжүүлсэн мал болон хэрэглээний зарлага, там малын зүй бус хорогдол болно.

Төллөлтийн хувь: Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Бойжилтын хувь: Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

100 эхээс бойжуулсан төл: Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 10-гаар үржүүлнэ.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо: Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

- 1 Буур – 20 ингэ
- 1 Азарга – 10 гүү
- 1 Бух – 25 үнээ
- 1 Хуц, ухна – 50-60 эм хонь, эм ямаа

Том малын үй бусын х орогдолд: Өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан гэх мэт) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

Малын хэрэглээний зарлага: Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч гаргана.

Малын хашааны хангамж: Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулан гаргана. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны хангамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямаа/ тоонд харьцуулна.

Тэжээл хангамж: Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд

харьцуулан гаргана. Малын хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлэн тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент: Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд доорхи

- | | |
|-------------------------|--|
| • Хадлан өвс | 0.45 |
| • Таримал тэжээл | 0.35 |
| • Даршны ургамал | 0.25 |
| • Гар тэжээл, хужир шүү | 1.0 |
| • Үр тарианы хаягдал | 0.9 |
| • Лай | 0.4 |
| • Сүрэл | 0.25 гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ. |

Малын тэжээлийн ангилал: Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал орох бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна. Үүнд:

- Бүдүүн тэжээл – Өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс
- Хүчит тэжээл – Үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг
- Шүүст тэжээл – бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал

Амьтны гаралтай тэжээлд үйлдвэрийн яс, цусны гурил зэрэг орно.

Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

II. МАЛ БҮХИЙ ӨРХ, МАЛЧДЫН ТОО, ТЭДГЭЭРИЙН СОЁЛ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Мал бүхий өрх, малчдын тоо: 2013 оны мал тооллогын дүнгээр дүүргийн хэмжээнд мал бүхий 960 өрх тоологдсон байна. Үүний 22.9 хувь буюу 220 өрх нь жилийн дөрвөн улирлын туршид малаа малладаг, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа малчин өрх, 77.1 хувь буюу 740 өрх нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөж үржүүлж буй малтай өрх байна.

Малчин , малтай өрхийн тоо /Хороогоор/

	Хороо	2010 он	2011 он	2012 он	2013 он
Малтай өрх	2-р хороо	4	1	1	1
	8-р хороо	3	1	1	1
	9-р хороо	48	43	51	51
	10-р хороо	26	9	9	6
	11-р хороо	296	343	305	228
	12-р хороо	25	3	3	2
	16-р хороо	-	-	-	1
	17-р хороо	11	9	10	3
	19-р хороо	3	1	3	-
	20-р хороо	720	667	668	631
	21-р хороо	10	7	7	6
	22-р хороо	2	1	1	-
	23-р хороо	35	20	20	20
	24-р хороо	2	2	3	-
	27-р хороо	-	-	1	1
	28-р хороо	-	10	12	8
Дүүргийн дүн		1187	1117	1095	960
Малчин өрх	9-р хороо	6	24	12	-
	11-р хороо	43	51	30	27
	20-р хороо	219	272	187	192
	28-р хороо	-	-	3	1
Дүүргийн дүн		268	347	232	220

2013 оны байдлаар мал аж ахуйн үйлдвэрлэлд 220 өрхийн 787 ам бүл ажиллаж байна. Түүний 423 нь мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шимийг амьжиргааны эх үүсвэрээ болгон амьдарч байгаа малчид байна. Малчдыг насны бүлгээр авч үзвэл 16.7 хувь нь 16-34 насны, 69.9 хувь нь 35-59 насны, 16.5 хувь нь 60 ба түүнээс дээш насны хүмүүс байна.

Малтай болон малчин өрх, малчдын тоо

Үзүүлэлт	2010 он	2011 он	2012 он	2013 он
Малтай өрх	1187	1117	1095	960
Түүний ам бүл	3490	3352	3343	2997
Малчин өрх	268	347	232	220
Түүний ам бүл	808	1048	800	787
Малчдын тоо	491	899	456	423
Үүнээс: -16-34 насны	96	210	74	113
-35-59 насны	253	338	307	296
-60 ба түүнээс дээш насны	142	351	75	14
Нийт малчдаас эмэгтэй	224	407	214	201
Насны бүтэц %	100	100	100	100
Үүнээс: -16-34 насны	19.6	23.6	16.2	16.7
-35-59 насны	51.5	37.6	67.3	69.9
-60 ба түүнээс дээш насны	28.9	38.8	16.5	16.5

Малтай болон малчин өрх, малчдын тоо



Малчдын соёл, ахуйн үзүүлэлт: 2013 оны мал тооллогоор нийт малчин өрхийн 89.1 хувь нь цахилгааны эх үүсвэртэй, 78.2 хувь нь сансарын антентай, 70.1 хувь нь телевизортой, 34.1 хувь нь радиотай, 55.5 хувь нь оёдлын машинтай, 97.3 хувь нь гар утастай, 5.0 хувь нь худагтай, 43.2 хувь нь автомашинтай, 4.5 хувь нь мотоциклтэй байна.

Малчдын соёл, ахуйн үзүүлэлт/төрлөөр/



Малчин өрхийн соёл, ахуйн зарим үзүүлэлтүүд

	Өрхийн тоо				Малчин өрхийн тоонд эзлэх хувь			
	2010	2011	2012	2013	2010	2011	2012	2013
Цахилгаан эх үүсгүүртэй	154	115	186	196	57.0	33.1	80.2	89.1
Телевизортой	240	236	173	156	88.9	68.0	74.6	70.1
Автомашинтай	110	147	91	95	40.7	42.4	39.2	43.2
Мотоциклтой	11	38	19	10	4.1	11.0	8.2	4.5

Цахилгаан үүсгүүртэй өрхийн тоо 2013 онд 196 болж, өмнөх оныхоос 10 буюу 5.3 хувиар, автомашинтай өрхийн тоо 4 буюу 4.4 хувиар тус тус өсч, харин телевизортой өрхийн тоо 17 буюу 9.8 хувиар, мотоциклтой өрхийн тоо 9 буюу 47.4 хувиар тус тус буурсан байна.

III. МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, СҮРГИЙН БҮТЭЦ


Малын тоо: 2013 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр дүүргийн хэмжээнд 960 өрхийн 42974 толгойд хүрч өнгөрсөн оныхоос 3893 толгой малаар буюу 9.9 хувиар өсчээ.

Малын тоо /төрлөөр/

Малын төрөл	2008	2009	2010	2011	2012	2013	2013/2011	
							Зөрүү	Хувь
Тэмээ	12	13	3	0	0	0	0	0
Адуу	2839	3282	3045	2531	2660	2819	159	6.0
Үхэр	11396	12369	11460	11172	12286	13463	1177	9.6
Хонь	18884	20716	11706	11057	11724	14015	2291	19.5
Ямаа	22824	24022	12269	12785	12411	12677	266	2.1
Бүгд	55955	60402	38483	37545	39081	42974	3893	9.9

Энэ жилийн тооллогоор адуу 159 буюу 6.0 хувиар, үхэр 1177 буюу 9.6 хувиар, хонь 2291 буюу 19.5 хувиар, ямаа 266 буюу 2.1 хувиар тус тус өссөн байна.

Малын тоо /төрлөөр/



Малын орлого, зарлага /төрлөөр/

	Оны эхэнд	Орлого			Зарлага			Оны эцэст	
		Худалдаж авсан, шилжиж ирсэн	Бэлэн тоологдсон т	Худалдсан, шилж	Алдсан	Зах зээлд борлуулсан	Хэрэглэсэн		Зүй бус хорогдол
Адуу	2660	765	524	950	10	72	69	29	2819
Үхэр	12286	2116	4316	3431	25	791	919	89	13463
Хонь	11724	3869	4776	4677	14	671	828	164	14015
Ямаа	12411	2939	3852	4826	3	628	922	146	12677
Дүн	39081	9689	13468	13884	52	2162	2738	428	42974

Дээрх хүснэгтээс харахад энэ жил бэлэн тоологдсон төл 13468 толгойгоор, худалдаж авсан, шилжиж ирсэн мал 9689 толгойгоор тус тус орлого талыг нэмэгдүүлж байхад харин бусдад худалдсан болон шилжүүлсэн малын тоо 13884 толгой, зах зээлд борлуулсан малын тоо 2162 толгой, хүнсэнд хэрэглэсэн малын тоо 2738 толгой болж зарлага талын гол үзүүлэлтийг тодорхойлж байна.

Малын сүргийн бүтэц: 2013 оны байдлаар нийт мал сүргийн 38.2 хувийг бод мал, 61.8 хувийг бог мал эзэлж байна.

Нийт сүрэгт адуу 7.0 хувь, үхэр 31.0 хувь, хонь 30.0 хувь, ямаа 32.0 хувийг тус тус эзэлж байна.




Нийт сүргийн бүтцэд таван төрлийн малын эзлэх хувийн жинг төрөл тус бүрээр доорх хүснэгтэнд гарган харуулбал:

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь

Малын төрөл	2008	2009	2010	2011	2012	2013
Бүгд	100	100	100	100	100	100
Тэмээ	0.02	0.02	0.008	0	0	0
Адуу	5.1	5.4	7.9	6.7	6.8	7.0
Үхэр	20.4	20.5	29.8	29.8	31.4	31.0
Хонь	33.7	34.3	30.4	29.4	29.9	30.0
Ямаа	40.8	39.8	31.9	34.1	31.9	32.0

Дээрх хүснэгтээс харахад дүүргийн хэмжээнд тэмээн сүрэг сүүлийн 3 жилд байхгүй, адуун сүргийн хувийн жин харьцангуй хэвийн, үхэр сүрэг өмнөх оныхоос өссөн байна. Мөн бог малын хувьд хонин сүргийн хувийн жин сүүлийн 3 жилийн туршид өсөлт, бууралт нь хэвийн тогтвортой байгаа ба харин ямаан сүргийн хувьд өмнөх оныхоос өссөн үзүүлэлттэй байна.

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь



Малын тоо хороогоор: Малын тоог хороо тус бүрээр нь харахад 2013 оны тооллогоор 9 дүгээр хороо 23 толгой малаар буюу 1.1 хувиар, 11 дүгээр хороо 657 толгой малаар буюу 18.1 хувиар 20 дугаар хороо 3185 толгой малаар буюу 18 хувиар малын тоо толгой өссөн ба бусад хороод нь малын төрөл тус бүрт бууралттай байна. Харин дүүргийн нийт малын 83-аас дээш хувийг эзэлдэг 20 дугаар хороо нь 2013 оны мал тооллогоор 42974 толгой мал тоолуулсан байна.

Малын тоо /хороогоор/

Хороо	Адуу			Үхэр			Хонь			Ямаа			Бүгд		
	2011	2012	2013	2011	2012	2013	2011	2012	2013	2011	2012	2013	2011	2012	2013
2-р хороо	-	-	-	3	4	3	-	-	-	-	-	-	3	4	3
8-р хороо	-	-	-	9	12	13	-	-	-	-	-	-	9	12	13
9-р хороо	26	11	11	376	415	543	573	721	682	1023	1006	940	1998	2153	2176
10-р хороо	1	2	-	87	81	76	-	-	-	-	-	6	88	83	82
11-р хороо	437	297	407	2060	2213	2429	652	535	623	730	596	839	3879	3641	4298
12-р хороо	-	-	-	24	18	31	-	-	-	-	-	-	24	18	31
16-р хороо	-	-	-	-	-	4	-	-	99	-	-	124	-	-	227
17-р хороо	5	4	3	59	54	25	-	-	-	-	-	-	64	58	28
19-р хороо	1	3	-	-	-	-	-	-	-	-	-	-	1	3	-
20-р хороо	2049	2331	2382	8259	9222	10008	9643	10275	12550	10816	10596	10669	30767	32424	35609
21-р хороо	-	-	-	29	36	33	68	71	55	126	118	87	223	225	175
22-р хороо	1	1	1	-	-	-	-	-	-	-	-	-	1	1	1
23-р хороо	3	3	3	119	82	158	121	122	3	90	95	12	333	302	176
24-р хороо	4	4	-	-	-	-	-	-	-	-	-	-	4	4	-
27-р хороо	-	-	-	-	3	2	-	-	-	-	-	-	-	3	2
28-р хороо	4	4	12	147	146	138	-	-	3	-	-	-	151	150	153
Тооллогын дүн	2531	2660	2819	11172	12286	13463	11057	11724	14015	12785	12411	12677	37545	39081	42974
Үүнээс: Амины мал	2509	2638	2793	11165	12275	13448	10986	11495	13904	12664	12201	12495	37324	38609	42640
ААНБ-ын мал	22	22	26	7	11	15	71	229	111	121	210	182	221	472	334

Хувийн /амины/ малын тоо: 2013 оны мал тооллогоор амины малын тоо 42640 толгой болж нийт малын 99.2 хувийг эзэлж байна. Энэ нь өнгөрсөн оныхоос 4031 толгой малаар буюу 10.4 хувиар өссөн байна. Нийт мал сүргээс адуун сүрэг 99.1 хувь, үхэр сүрэг 99.9 хувь, хонин сүрэг 99.2 хувь, ямаан сүрэг 98.6 хувь нь хувийн аж ахуйд байна.

Хувийн малтай өрх, малын тоо

Он	Малтай өрх	Бүгд	Үүнээс:					1 өрхийн дундаж мал
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	
2008	1195	55955	12	2839	11396	18884	22824	47
2009	1293	60402	13	3282	12369	20716	24022	47
2010	1187	38165	3	3045	11460	11706	12269	32
2011	1117	37324	0	2531	11172	11057	12785	33
2012	1095	38609	0	2660	12286	11724	12411	35
2013	960	42640	0	2819	13463	14015	12677	44

2013 оны байдлаар 1 өрх дундажаар 44 толгой малтай болсон нь өнгөрсөн жилээс 25.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Малтай өрхийн малын бүлэглэлт

	Өрхийн тоо			Дүнд эзлэх хувь			Малын тоо		
	2011	2012	2013	2011	2012	2013	2011	2012	2013
10 хүртэл малтай	532	442	374	47.6	44.2	38.9	2509	2273	2053
11-30 малтай	288	274	285	25.8	27.3	29.7	5056	5096	5313
31-50 малтай	91	101	111	8.1	10.1	11.6	3386	3944	4360
51-100 малтай	91	82	93	8.1	8.2	9.7	6192	5540	6656
101-200 малтай	68	58	51	6.1	5.8	5.3	9992	7968	7352
201-500 малтай	45	40	38	4.0	3.9	4.2	8807	11503	10375
501-999 малтай	2	4	8	0.3	0.5	0.6	1382	2285	6531
Бүгд	1117	1001	960	100	100	100	37324	38609	42640

2013 оны мал тооллогоны дүнгээс малын бүлэглэлт тус бүрээр авч үзэхэд 10 хүртэлх толгой малтай 1 өрхөд 5.5 толгой мал, 11-30 малтай 1 өрхөд 18.6 толгой мал, 31-50 малтай 1 өрхөд 39.3 толгой мал, 51-100 малтай 1 өрхөд 71.6 толгой мал, 101-200 малтай 1 өрхөд 144.2 толгой мал, 201-500 малтай 1 өрхөд 273 толгой мал, 501-999 малтай 1 өрхөд 816.4 толгой мал тус тус ноогдож байна.

Хээлтэгч мал: 2013 оны эцэст 19495 толгой хээлтэгч мал тоологдсон нь өнгөрсөн оныхоос 705 толгойгоор буюу 3.8 хувиар өссөний дотор гүү 2 толгой, үхэр 278 толгой, эм хонь 627 толгойгоор тус тус өсч, харин эм ямаа 202 толгойгоор буурсан байна.

Хээлтэгч малын тоо /төрлөөр/


Малын төрөл	2008	2009	2010	2011	2012	2013	2013/2012	
							Зөрүү	Хувь
Тэмээ	6	6	1	0	0	0	0	0
Адуу	832	1034	982	832	834	856	22	2.6
Үхэр	5753	6052	5858	5854	6132	6361	229	3.7
Хонь	9684	10964	6556	5532	6159	7201	1042	16.9
Ямаа	11522	12782	7521	6572	6370	6578	208	3.3
Бүгд	27797	30838	20918	18790	19495	20996	1501	7.7

Хээлтэгч мал нийт малын 48.9 хувийг эзэлж байна.

Үүнд:

- ❖ Адуун сүргийн – 30.4 хувь
- ❖ Үхэр сүргийн – 47.2 хувь
- ❖ Хонин сүргийн – 51.4 хувь
- ❖ Ямаан сүргийн – 51.3 хувь

Хээлтэгч малын тоо



Малын тооны өсөлт, бууралтанд нөлөөлсөн үзүүлэлтүүд

	2010	2011	2012	2013	2013/2012	
					Зөрүү	Хувь
Бэлэн тоологдсон төл	8992	12078	12273	13468	1195	9.7
Том малын зүй бус хорогдол	6796	441	127	428	301	3.4 дахин
Хээлтэгч малын тоо	20918	18790	19495	20996	1501	7.7
Хээл хаясан хээлтэгч	778	57	60	187	127	3.1 дахин
Сувайрсан хээлтэгч	1977	2548	611	2065	1454	3.4 дахин

2013 оны мал тооллогоны дүнгээс харахад том малын зүй бус хорогдол 301 толгой буюу 3.4 дахин, хээл хаясан хээлтэгч 127 толгой буюу 3.1 дахин, сувайрсан хээлтэгч 1454 буюу 3.4 дахин буурсан үзүүлэлтэй байгаа хэдий боловч бойжуулсан төл 1195 толгой буюу 9.7 хувиар, хээлтэгч малын тоо 1501 толгой буюу 7.7 хувиар өссөн байгаа нь малын үзүүлэлтэнд эерэгээр нөлөөлсөн байна.

Бойжуулсан төл

	2008	2009	2010	2011	2012	2013	2013/2012	
							Зөрүү	Хувь
Ботго	2	1	-	-	-	-	-	-
Унага	353	488	307	455	454	524	70	15.4
Тугал	3330	3785	3347	3174	4058	4316	258	6.4
Хурга	6485	6230	3135	4126	4007	4776	769	19.2
Ишиг	7478	6969	2203	4323	3754	3852	98	2.6
Бүгд	17648	17473	8992	12078	12273	13468	1195	9.7

2013 оны мал тооллогоор бойжуулсан төлийн тоо 13468 толгой болж өнгөрсөн оныхоос 1195 толгойгоор буюу 9.7 хувиар өссөн байна. Бойжуулсан төлийн тоо өнгөрсөн онтой харьцуулахад малын төрөл тус бүр дээр өссөн үзүүлэлттэй байна.

Өнгөрсөн оны тооллогоор 19495 хээлтэгч төллөхөөр тоологдсон бөгөөд:

- ❖ Хээлтэй малын орлогоор 4803 толгой мал нэмэгдэж
- ❖ Хээлтэй мал 4651 зарлагдаж
- ❖ Хээл хаясан 187 толгой мал
- ❖ Сувайрсан 2065 толгой мал тус тус хасагдаж нийт 17395 хээлтэгч төллөсөн байна.

Төл бойжилт, төлийн орлого, зарлага, төрлөөр

	Төллөсөн хээлтэгч	Гарсан төл	Хорогдсон төл	Бойжсон төл	Худалдаж авсан, шилжиж ирсэн	Худалдсан, шилжүүлсэн
Унага	573	573	49	524	-	-
Тугал	4441	4445	134	4311	67	62
Хурга	6321	6321	235	6086	3	1313
Ишиг	6060	6060	302	5758	5	1911
Бүгд	17395	17399	720	16679	75	3286

Том малын зүй бүс хорогдол: 2013 оны тооллогоор 428 том мал хорогдсон бөгөөд өнгөрсөн оныхоос 301 толгойгоор буюу 3.4 дахин буурсан байна. Нийт хорогдсон малын 6.8 хувийг адуун сүрэг, 20.8 хувийг үхэр сүрэг, 38.3 хувийг хонин сүрэг, 34.1 хувийг ямаан сүрэг тус тус эзэлж байна.

Том малын зүй бүс хорогдол

	2008	2009	2010	2011	2012	2013	2013/2012	
							Зөрүү	Хувь
Адуу	23	31	215	49	24	29	5	20.8
Үхэр	114	51	627	133	42	89	47	2.1 дахин
Хонь	97	60	2626	129	36	164	128	4.5 дахин
Ямаа	109	99	3328	130	25	146	121	5.8 дахин
Бүгд	343	241	6796	441	127	428	301	3.4 дахин

2013 оны тооллогоор нийт хорогдсон малын 72 толгой мал буюу 16.8 хувь нь өвчнөөр хорогдсон байна.


III. ТЭЖЭЭВЭР АМЬТАД

2013 онд дүүргийн хэмжээнд 2993 гэрийн тэжээвэр амьтад тоологдсон бөгөөд дийлэнх нь буюу 82.4 хувийг гахай эзэлж байна.

Тэжээвэр амьтад /төрлөөр/

	2011	2012	2013	2013/2012	
				Зөрүү	Хувь
Гахай	1039	1160	2465	1305	2.1 дахин
Шувуу	6416	552	470	82	85.1
Цаа	-	1	1	-	-
Илжиг	-	1	-	-	-
Туулай	34	57	34	-23	59.6
Минж	-	23	23	-	-
Нийт	7489	1794	2993	1199	1.6 дахин

Тэжээвэр амьтад



Тэжээвэр амьтдын тоо /Хороогоор/

Хороо	Нохой	Муур	Гахай	Шувуу	Үүнээс: Тахиа	Цаа	Илжиг	Туулай	Минж
1-р хороо	37	2	0	0	0	0	0	0	0
2-р хороо	748	5	0	0	0	0	0	0	0
3-р хороо	18	1	0	0	0	0	0	0	0
4-р хороо	426	3	0	0	0	0	0	0	0
5-р хороо	2412	54	0	0	0	0	0	0	0
6-р хороо	9	1	0	0	0	0	0	0	0
7-р хороо	22	2	0	0	0	0	0	0	0
8-р хороо	348	7	0	0	0	0	0	0	0
9-р хороо	1865	16	89	0	0	0	0	0	0
10-р хороо	619	12	2	3	3	0	0	0	0
11-р хороо	1067	11	1919	211	123	0	0	16	0
12-р хороо	810	6	0	49	47	0	0	0	0
13-р хороо	437	5	0	0	0	0	0	0	0
14-р хороо	464	6	0	0	0	0	0	0	0
15-р хороо	14	1	0	0	0	0	0	0	0
16-р хороо	122	0	0	0	0	0	0	0	0
17-р хороо	653	30	0	0	0	0	0	0	0
18-р хороо	27	1	0	0	0	0	0	0	0
19-р хороо	881	4	0	0	0	0	0	0	0
20-р хороо	733	7	323	70	40	1	0	10	23
21-р хороо	1479	0	83	40	30	0	0	0	0
22-р хороо	458	1	0	0	0	0	0	0	0
23-р хороо	1019	7	49	66	58	0	0	0	0
24-р хороо	816	3	0	0	0	0	0	0	0
25-р хороо	10	1	0	0	0	0	0	0	0
26-р хороо	13	0	0	0	0	0	0	0	0
27-р хороо	812	0	0	0	0	0	0	0	0
28-р хороо	399	39	0	31	31	0	0	8	0
Нийт	16718	225	2465	470	332	1	0	34	23

ДҮГНЭЛТ

Өнгөрсөн жилүүдэд дүүргийн малын тоо ихээхэн буурсан үзүүлэлттэй байсан шалтгаан нь мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс малтай өрхийг нүүлгэн шилжүүлж, 11, 20 дугаар хороодод малтай өрх байхыг зөвшөөрсөнтэй холбоотой юм. Гэтэл 2013 оны “Мал, тэжээвэр амьтдын тооллого”-ын дүнгээр 42974 толгой мал тоолуулж 3893 толгой мал буюу 9.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь тус дүүргийн нийт малын 80-аас дээш хувийг эзэлдэг 20 дугаар хороонд малын сүрэг тус бүр дээр өссөн учраас дүүргийн өсөлтөнд нөлөөлж байна.

Дүүргийн хэмжээнд мал, тэжээвэр амьтад бүхий 14 хорооны 1 аж ахуйн нэгж байгууллага, 960 өрхийн 42974 толгой мал тоологдсныг төрөл тус бүрээр авч үзвэл:

- ❖ Адуу – 2819
- ❖ Үхэр – 13463
- ❖ Хонь – 14015
- ❖ Ямаа – 12677 толгой малтай байв

Бог малын бүтцэд 2013 оны байдлаар бог малын 52.5 хувийг хонин сүрэг, 47.5 хувийг ямаан сүрэг эзэлж байна. Нийт бог малын 47.5 хувийг ямаан сүрэг эзэлж байгаа нь өнгөрсөн оныхоос өссөн үзүүлэлт байна.

2013 оны мал тооллогоор амины малын тоо 42640 толгой болж нийт малын 99.2 хувийг эзэлж байна. Энэ нь өнгөрсөн оныхоос 4031 толгой малаар буюу 10.4 хувиар өссөн байна.

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Нэгтгэн боловсруулсан мэргэжилтэн:

Б.Эрхэмбаяр

Хянасан хэлтсийн дарга:

Н.Энхтуяа

E-mail: bayanzurkh@nso.mn

Утас: 267349, 261728, 261019